


**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН 2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

дд	Гүйцэтгэх ажил	Хугацаа	Гүйцэтгэл
1	Хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавина.	Тухай бүр	<p>ҮСХ-ны даргын 2017 оны А/14 тоот тушаалаар батлагдсан “Нийгэм, эдийн засгийн сар, улирлын бюллетень, танилцуулгыг бэлтгэхэд баримтлах нэгдсэн заавар”-ын хэрэгжилтэд хяналт тавихад хэлтсийн хэмжээнд тайлант оны 4 дүгээр сарын танилцуулгаас эхлэн хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>Аймгийн Засаг даргын 2017 оны А/169 тоот захирамжийн биелэлтэд хяналт тавин ажиллав. Хагас жилийн малын түүвэр судалгааг орон нутагт амжилттай зохион байгуулж түүврээр сонгогдсон 241 өрх аж ахуйн нэгжийг тооллогод бүрэн хамруулан шивэлтийг анхан шатны нэгж дээр хугацаанд нь хийлгэж ҮСХ-нд мэдээллээ. Нийт 241 нэгжийн 10 хувь буюу 24 өрхөд аймгийн комиссоос хяналт хийсэн байна.</p>
2	Хэлтсийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт хийнэ.	6, 12 дугаар сарын 10-ны дотор	Хэлтсийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт хийхэд хугацаа хоцорсон мэдээ тайлан гараагүй болно. /Сум багаас ирүүлсэн албан ёсны болон захиргааны Статистик мэдээ тайлангийн явцад ажилтан бүр хариуцсан мэдээ тайлангийн алдаа хоцрогдлын бүртгэл хөтлөн тухай бүр нь тодруулга хийж, засуулж авсан болно. /
3	Сүмбэр сумын Статистик мэдээний үнэн бодит байдал, хадгалалт хамгаалалт, холбогдох тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт хийнэ.	5 дугаар сар	<p>Статистикийн хэлтсийн даргын 2017 оны 5 дугаар сарын 08-ны өдөр баталсан удирдамжийн дагуу 2017 оны 5 дугаар сарын 19-ны өдөр Сүмбэр суманд дотоод хяналт хийж арга зүйн зөвлөгөө өглөө.</p> <p>Гарсан алдаа дутагдлыг газар дээр нь хамтран арилгаж, цаашид мэдээ тайланг батлагдсан маягтын дагуу гаргах, хадгалах, хүчингүй болсон маягыг тухай бүр нь устгаж байхыг анхааруулав. Хяналтын тайланг хэлтсийн 2017 оны 49 тоот албан бичгээр хүргүүлэв.</p>
4	Шивээговь сумын Статистик мэдээний үнэн бодит байдал, хадгалалт хамгаалалт, холбогдох	6 дугаар сар	Статистикийн хэлтсийн даргын 2017 оны 6 дугаар сарын 13-ны өдөр баталсан удирдамжийн дагуу 2017 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Шивээговь суманд дотоод хяналт хийж арга зүйн зөвлөгөө өглөө.

	тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт хийнэ.		Гарсан алдаа дутагдлыг газар дээр нь хамтран арилгаж, тооллого, судалгааг хийж дууссан даруйд баталгаажуулалт хийж байхыг анхааруулав. Хяналтын тайланг хэлтсийн 2017 оны 61 тоот албан бичгээр хүргүүлэв.
5	Баянтал сумын Статистик мэдээний үнэн бодит байдал, хадгалалт хамгаалалт, холбогдох тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт хийнэ.	8 дугаар сар	Хугацаа болоогүй
6	Хэлтсийн өмч ашиглалт, хамгаалалт, санхүүгийн ил тод байдалд хяналт тавина.	6, 12 дугаар сарын 25-ны дотор	Санхүүгийн ил тод байдалд хяналт тавихад мэдээллийн самбарт санхүүгийн өглөг, авлагын мэдээнүүдийг сар бүр байршуулж хэвшсэн байна. Хариуцсан ажилтанд төсөв санхүүгийн холбогдох хууль журмыг сайтар судлах үүрэг өглөө.
7	Хэлтсийн албан хэрэг хөтлөлт, архив цэгцлэлтэд хяналт тавина.	5, 10 дугаар сарын 25-ны дотор	Статистикийн хэлтсийн даргын 2017 оны 5 дугаар сарын 08-ны өдөр баталсан удирдамжийн дагуу 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдөр Статистикийн хэлтсийн архив, бичиг хэргийн хөтлөлт, эмх цэгцлэлтийн явцад хяналт хийж, зөвлөгөө өгч ажиллалаа. Статистикийн хэлтсийн архив, бичиг хэргийн хөтлөлт, эмх цэгцлэлтийн явцад хяналт хийхэд хариуцсан ажилтан нь аймгийн ЗДТГ-ын архивын тасгийн даргаас болон бусад байгууллагуудын тухайн ажлыг хариуцсан ажилтнуудаас заавар зөвлөгөө авч ажилласан байна. Гарсан алдаа дутагдлыг хэрхэн засаж залруулах талаар заавар зөвлөгөө өгч зарим зүйлийг хамтран хийж цэгцэлсэн болно. 2017 оны 6 дугаар сарын 15-ны өдөр дутуу ажлуудыг шалгаж дуусгав. Мэргэжлийн байгууллагаас сургалт авах, архивын стандарт, зааврыг ажлын хэрэгцээндээ байнга ашиглаж хэвших, харилцагч байгууллагуудын нэр болон цахим хаягийн жагсаалт, архивын материал ашиглалтын бүртгэл хөтлөлтийг тухай бүр нь хөтөлж байх үүргийг хариуцсан ажилтанд өгөв.

Тайлан нэгтгэсэн: Ахлах мэргэжилтэн



Я.Отгонбаяр

2017-6-25